

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд
өөрчлөлт оруулах тухай

Нэг. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 61 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-ний “Хүснэгт-1”-д дор заасан өөрчлөлтийг оруулсугай.

- 1.1. №2-ын Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх, Тусгай дугаарт мессежний үйлчилгээ, Монгол Улсын нутаг дэвсгэрт “1,500.0 гэснийг 4,800.0” гэж
- 1.2. №3-ын Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх, Улс хоорондын ярианы үйлчилгээ “5,000.0 гэснийг, Хот, хот хоорондын ярианы/ дата үйлчилгээ(үүрэн), Монгол Улсын нутаг дэвсгэрт “55,000.0 гэснийг, нэгтгэж Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт 98,500” гэж
- 1.3. №3-ын Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх, Хот, хот хоорондын ярианы/дата үйлчилгээ (суурин), Монгол Улсын нутаг дэвсгэрт “6,800.0 гэснийг 11,200.0” гэж
- 1.4. №3-ын Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх, Сансрын хөдөлгөөнт холбооны үйлчилгээ, Монгол Улсын нутаг дэвсгэрт “800.0 гэснийг 5,000.0” гэж
- 1.5. №3-ын Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх, Интернэтийн үйлчилгээ, Монгол Улсын нутаг дэвсгэрт “2,000.0 гэснийг 4,950.0” гэж, Аймагт “300.0 гэснийг 550,0” гэж
- 1.6. №5-ын Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх, Утастай, утасгүй сүлжээгээр олон суваг дамжуулах үйлчилгээ, Монгол Улсын нутаг дэвсгэрт “14,900.0 гэснийг 29,900.0” гэж, Улаанбаатар “5,500.0 гэснийг 9,500.0” гэж, Аймагт “1,200.0 гэснийг 2,400.0” гэж
- 1.7. №5-ын Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх, Хиймэл дагуулын сүлжээгээр олон суваг дамжуулах үйлчилгээ, Монгол Улсын нутаг дэвсгэрт “15,000.0 гэснийг 29,900.0” гэж
- 1.8. №8-ын Сансарын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх, Сансарын холбооны сүлжээ, Монгол Улсын нутаг дэвсгэрт “3,000.0 гэснийг 4,950.0” гэж
- 1.9. №9-ийг Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх, Улс хоорондын сүлжээ, Монгол Улсын нутаг дэвсгэрт “25,000.0 гэснийг, Улс хоорондын транзит урсгал дамжуулах, Монгол Улсын нутаг дэвсгэрт “12,500.0 гэснийг, нэгтгэж Олон улсын цахилгаан холбооны сүлжээ, Монгол Улсын нутаг дэвсгэрт 59,000.0” гэж
- 1.10. №10-ын Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх, Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт, “1,800.0 гэснийг 2,950” гэж